БАТЛАВ:

ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ” ТӨААТҮГ -ын

ЗАХИРАЛ Д.ГАНБОЛД

“ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТӨВ” ТӨААТҮГ

БАЙГУУЛЛАГЫН
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ПРОГРАММ
БОЛОВСРУУЛАХ

АЖЛЫН ДААЛГАВАР-2

УЛААНБААТАР
2021

АГУУЛГА

БҮЛЭГ №1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

БҮЛЭГ №2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШААРДЛАГА

БҮЛЭГ №3. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

БҮЛЭГ №4. ШАЛГАЛТ ТУРШИЛТ, ЧАНАРЫН БАТАЛГАА

БҮЛЭГ №5. ХАВСРАЛТ

БҮЛЭГ №1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

0.1 Системийн чиглэл

0.1.1 “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-т ашиглагдаж буй санхүүгийн программыг боловсронгуй болгох, байгууллагтай холбоотой статистик, мэдээ тайлан гаргах, мэдээлэх, хяналт тавих үйл ажиллагааг боловсронгуй болгох,

0.1.2 Санхүүгийн программ нь “Геологийн судалгааны төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах бөгөөд байгууллагын баримт бичиг, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн талаарх дэлгэрэнгүй болон хураангуй тайлан гаргах стандартыг нэвтрүүлэх боломжтой байх ба Сангийн сайдын тушаал, шийдвэр, санхүүгийн тайлагнал болон баримт бичиг бүртгэлийн стандартын зэрэг бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн стандарт шаардлагыг хангасан байвал зохино,

0.2 Захиалагчийн үйл ажиллагааны зорилт

0.2.1 Захиалагч нь өөрийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд өдөр тутам ашиглах, ингэснээр байгууллагын нөөц төлөвлөлт, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв бодитой байдлыг хангах, улмаар санхүүгийн тайлан дахь өглөг, авлага, зардлын тайлагналыг үнэн зөв бодит болгоход чиглэгдсэн үйл ажиллагааг хангах зориулалт бүхий программ нэвтрүүлнэ. Ингэснээр байгууллагын нэгдсэн санхүүгийн мэдээллийн сан бий болж байгууллагын дотоод зохион байгуулалт төдийгүй санхүүгийн удирдлага хяналтын нэгдсэн тогтолцоо бий болгохоос гадна мэдээллийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтын найдвартай ажиллагааг хангаж, санхүүгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн цаг хугацаа хэмнэж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх өндөр үр ашигтай юм.

0.2.2 Энэхүү санхүүгийн программыг нэвтрүүлснээр байгууллагын дотоод үйл ажиллагааны процесс нь түргэн шуурхай, найдвартай болох, мөн төлөвлөл болон гүйцэтгэлтэй холбоотой тайлан мэдээ гаргах үйл ажиллагаанд хяналт тавихад хялбар болно.

0.2.3 Санхүүгийн программ нь байгууллагын дотоод үйл ажиллагааг удирдлаа болон гүйцэтгэлийн түвшинд нэгдсэн мэдээллийн сангийн тусламжтайгаар хамтатган төлөвлөх, гүйцэтгэх, хянах боломжийг

олгож байгаа нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа төдийгүй төлөвлөлт хяналтын үйл ажиллагаанд тулгардаг бэрхшээлүүдийг багасгах, механик алдаа гарах эрсдэлийг эрс бууруулах, тайлан илгээх хүлээн авах үйл ажиллагааг автоматжуулснаар цаг хугацааг хэмнэх зэрэг материаллаг болон материаллаг бус зардлуудыг багасгах зэрэг өндөр үр өгөөжийг үзүүлнэ

0.2.4 Санхүүгийн программ нь Хүний нөөц, Харилцагчийн менежмент, Нягтлан бодох бүртгэлийн үндсэн модулиудыг агуулах бөгөөд энэ нь байгууллагын дотоод үйл ажиллагаанд бүхэлд нь хяналт тавих боломжийг бүрдүүлж өгнө

0.3 Техникийн шаардлагад хэрэглэсэн товчилсон нэр

0.3.1 Техникийн шаардлагад ашигласан байгууллагын болон техникийн товчилсон нэр томьёоны хүснэгт.

	Товчилсоннэр	Тайлбар
	DBMS	Мэдээллийн баазын удирдлагын систем
	DOS	Дискийн үйлдлийн систем
	dpi	Нэг инч дэх цэгийн тоо
	Ethernet	IEEE 802.3 Стандарт LAN протокол
	GB	Гегабайт
	Hz	Герц (нэг секунд тутам дахь давтамжийн тоо)
	IEEE	Цахилгаан,электроникийн инженерүүдийн институт
	ISO	НҮБ-ын олон улсын стандартын байгууллага
	KB	Килобайт
	kVA	Киловольтампер
	LAN	Дотоод сүлжээ
	MB	Мегабайт
	MTBF	Алдаа-гэмтэл хоорондын хугацаа
	NIC	Сүлжээний хэрэглэгчийн карт
	NOS	Сүлжээний үйлдлийн систем
	ODBC	Open Database Connectivity
	OLE	Object Linking and Embedding
	OS	Үйлдлийн систем
	PCL	Принтерийн командын хэл
	RAID	Redundant array of inexpensive disks
	RAM	Санахой
	RISC	Бууруулсан зааварчилгаа
	SCSI	Компьютерын жижиг систем
	SNMP	Сүлжээний удирдлагын жишиг протокол
	SQL	Structured Query Language-Программхангамжийнхэл
	TCP/IP	Дамжих хяналтын протокол / Интернэт протокол

БҮЛЭГ №2. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН ГҮЙЦЭТГЭЛИЙН ШААРДЛАГА

1.1 Системд тавигдах үйлажиллагааны шаардлага

1.1.1 Санхүүгийн программ нь байгууллагын дотоод үйл ажиллагааны дараах процессуудыг автоматчилахад чиглэгдсэн байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн бүртгэл
- Цалин хөлсний бүртгэл
- Бараа материалын бүртгэл
- Үндсэн хөрөнгийн бүртгэл
- Төслийн бүртгэл
- Борлуулалтын бүртгэл
- Дотоод тээврийн бүртгэл
- Хүний нөөцийн бүртгэл
- Харилцагчийн менежмент
- Нөөцийн бүртгэл
- Мөнгөн урсгалын мэдээ
- Санхүүгийн тайлан баланс
- ХАОАТ-ын тайлан
- НДШ тайлан

Мөн одоо ашиглагдаж буй бусад системүүдтэй зохицон ажиллах тэдгээрээс мэдээлэл импортлох болон тэдгээр системүүдийн шаардлагад нийцсэн өгөгдлүүдийг экспортлох зэрэг нэмэлт фунцкүүдийг агуулсан байна.

1.1.2 Санхүүгийн программ нь Сангийн сайдын тушаал, шийдвэр холбогдох заавар журмын дагууболовсруулагдах ба тэдгээрт нийцсэн стандарт кодчилолуудыг ашигласан байна.

1.2 Санхүүгийн программын ажиллагаа, гүйцэтгэлийншаардлага

Санхүүгийн программ нь байгууллагын өдөр тутмыг үйл ажиллагааны процессыг тухай бүр бүртгэх, холбогдох баримт бичиг эх хувийг хавсаргах, анхан шатны баримтад үндэслэсэн нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээ бүртгэх, хяналт хийх зэрэг үйл ажиллагааг бүртгэлжүүлэх, автоматжуулахад зориулагдсан байна.

Санхүүгийн программ нь дараах дэд модулиудаас бүрдэх бөгөөд тэдгээр нь хоорондоо нягт уялдаа холбоотой байна.

1. Мөнгөн хөрөнгийн модуль

Тус газар нь хөрөнгө оруулалтын болон үйл ажиллагааны өдөр тутмын мөнгөн гүйлгээг олноор хийдэг тул дараах нэмэлт шаардлагуудыг агуулсан байна.

- ✓ Санхүүгийн бусад программ дээр байдаг мөнгөн гүйлгээний бүртгэлийг бүгдийг оруулсан байх
- ✓ Төлбөрийн даалгаврыг олноор хэвлэдэг байх
- ✓ Шүүлт, хайлтыг хурдан шуурхай хийдэг байх
- ✓ 2 дансны гүйлгээг хооронд нь сольдог байх
- ✓ Банкнаас хуулга шивж оруулдаг хэсэг хялбар байх
- ✓ Мөнгөн гүйлгээг төсөл тус бүрээр нь ангилж хийх боломжтой байх
- ✓ Сар бүр төсөв төлөвлөгөөг харьцуулсан мэдээ тайлан гардаг байх
- ✓ Өглөг авлагын журналаас тооцоо нийлсэн актыг байгууллага бүр дээр тухай бүр хэвлэдэг байх
- ✓ Мөнгөн гүйлгээний журналаас талбар бүрээр групплэх эрэмблэх боломжтой байх
- ✓ Гүйлгээг түгждэг байх
- ✓ Олон хэрэглэгчийн горимд ажилладаг байх
- ✓ Хэрэглэгчийн эрхийг нарийн заадар байх
- ✓ Төлөвлөгөөнд тусгасан зардлын ангилалтай байх
- ✓ НӨАТ болон ХАОАТ авдаг тохируулгатай байх

2. Цалин хөлсний модуль

- ✓ Бусад цалингийн программ дээр байдаг бүх аргачлал байна
- ✓ 3000-5000 ажилтны цалин боддог байх
- ✓ Олон хэрэглэгчийн горимд нэг зэрэг ажилладаг байх
- ✓ Ажилтны нэмэгдэл, суутгалыг олон аргачлалаар оруулдаг байх
- ✓ Цалингийн дансны бичилтийг төсөл дээр бичдэг байх
- ✓ Овог, нэр, регистрийн дугаараар эрэмбэлдэг, шүүдэг байх
- ✓ Сар бүр цалин өндөрлөдөг байх
- ✓ Хэрэглэгчийн эрхийг нарийн заадаг байх

3. Бараа материалын модуль

- ✓ Бусад программ дээр байдаг бүх аргачлал байна
- ✓ Олон хэрэглэгчийн горимд ажилладаг байх

- ✓ Хэрэглэгчийн эрхийг нарийн заадаг байх
- ✓ Гүйлгээг түгждэг байх
- ✓ Өртөгт шингэх түүхий эдийн зарцуулалтыг технологийн картын дагуу автоматаар хийдэг байх
- ✓ Түүхий эдийн үлдэгдэл байх болох хэмжээнээс багасвал дохио өгдөг байх
- ✓ Тооллогын бүртгэл болон эд хариуцагчийн бүртгэлийг нарийн хийдэг байх

4. Үндсэн хөрөнгийн модуль

- ✓ Бусад программ дээр байдаг бүх аргачлал байна
- ✓ Олон хэрэглэгчийн горимд ажилладаг байх
- ✓ Хэрэглэгчийн эрхийг нарийн заадаг байх
- ✓ Гүйлгээг түгждэг байх
- ✓ Тооллогын бүртгэл болон эд хариуцагчийн бүртгэлийг нарийн хийдэг байх
- ✓ Элэгдлийн жилийг нарийн оруулж, шаардлагатай тохиолдолд засварлан дансны бичилтийг автоматаар хийдэг байх
- ✓ Хөрөнгийн зургийг оруулан хадгалдаг байх

5. Борлуулалт болон дотоод тээврийн бүртгэл

- ✓ Олон хэрэглэгчийн горимд ажилладаг байх
- ✓ Хэрэглэгчийн эрхийг нэарийн заадаг байх
- ✓ Гүйлгээг түгждэг байх
- ✓ Борлуулалтыг өдөр бүр хянадаг байх
- ✓ Борлуулалтын системтэй холбогдож өдөр бүр шахмал түлшний зарлагыг татдаг байх
- ✓ Борлуулалтын тайланг борлуулагч бүрээр болон үйлдвэр тус бүрээр гаргадаг байх
- ✓ Дотоод тээврийн бүртгэлийг тээвэрлэгч тус бүрээр хийдэг байх
- ✓ Борлуулалт тээвэрлэлтийг харьцуулан хяналт хийх боломжтой байх
- ✓ Үйлдвэрлэл болон борлуулалтыг харьцуулан хяналт тавих боломжтой байх
- ✓ Шахмал түлшний нөөцийн бүртгэлийг хянадаг байх

6. Харилцагчийн гэрээний бүртгэл

- ✓ Харилцагч тус бүрээр гэрээг бүртгэдэг байх
- ✓ Гэрээний төлбөр болон гэрээний биелэлтийг нарийн оруулж үлдэгдлийг хянадаг байх
- ✓ Гэрээт ажлын тайланг тухай бүрт бүртгэж, архивладаг байх

7. Тайлан баланс

- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон станлартад нийцсэн маягтын дагуу холбогдох тайлан, мэдээг гаргадаг байх, PDF, MS Excel рүү хөрвүүлдэг байх
- ✓ Санхүүгийн тайлагналын хувьд аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга /Э-Баланс/ , Төсөвт байгууллагын санхүүгийн тайлан, тодруулга /Э-Тайлан/ системийн тайлангийн стандартад нийцсэн тайлан бэлтгэн тус сайтууд руу хөрвүүлэн татах боломжтой байна.

БҮЛЭГ №3. ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

2.0 Техникийн ерөнхий шаардлага

2.0.1 Хэлний шаардлага: Бүхий л мэдээлэл нь Монгол хэл дээр байна.Ялангуяа, технологийн болон программ хангамжийн бүх дэлгэцийг ISO-8859-1 ба UTF-8 Unicode тэмдэгтийн тохиргоо болон UTF-8 Unicode-ийн дагуу эрэмбэлэгдэх ёстой.

2.0.2 ОГНОО: Бүх мэдээллийн технологи нь зөвхөн 21 дүгээр зууны огнооны мэдээллээр хязгаарлагдахгүйгээр огнооны тоон өгөгдөл-мэдээллийг зөв харуулах, тооцоолох болон дамжуулах боломжтой байх ёстой.

2.0.3 Цахилгаан эрчим хүч: Ажиллагааны буюу эрчим хүчинд залгагддаг бүх тоног төхөөрөмж нь220v +/- 20v, 50Hz +/- 2Hz хүчдэлд ажиллах ёстой. Бүх тоног төхөөрөмж ньМонголын улсынMNS IEC 60227 стандартын эрчим хүчний залгууртай байна.

2.0.4 Орчин: Хэрэв өөрөөр тусгайлан заагаагүй бол, бүх тоног төхөөрөмж нь 10-30 хэм дулаан, 20-80 хувийн чийгшил, 0-39 куб метр тоосжилтын нөхцөлд ажиллах ёстой.

2.0.5 Аюулгүй байдал:

2.0.5.1 Хэрэв өөрөөр тусгайлан заагаагүй бол, бүх тоног төхөөрөмжийн ажиллахдуу чимээ-нүргээний түвшин нь 55 децибелээс ихгүй байна.

2.0.5.2 Бүх цахилгаан тоног төхөөрөмжийн ялгаруулах цахилгаан соронзон энерги-эрчим хүч ньUSFCCB ангилал эсхүл EN 55022 ба EN 50082-1 эсхүл үүнтэй дүйх ялгаруулалтын стандартыг хангасан байна.

2.1 Техник хангамжийн тодорхойлолт

2.1.1 Сервер компьютер:

2.1.1.1 Боловсруулах нэгжийн ажиллагаа: Тендерт зориулж санал болгох боловсруулах нэгжийн ажиллагааны түвшин хамгийн багадаа,

(a) биелүүлэх

Үйлдлийн систем:	Windows 2008+ Server, Linux Server
Санах ой:	4GBтүүнээс дээш
Хатуу диск:	100GB сул зайтай байх
Процессор:	2.4GHz түүнээс дээш

Тог баригч: UPS 1000 буюу түүнээс дээш

(б) ажиллагааны оролт-гаралтыг дараах байдлаар хангана

Хэрэглэгчийн дэлгэц: 1024x768 нягтрал бүхий 16bit өнгийг дэмждэг байна. Хэрэглэгчийн компьютер нь LAN (дотоод сүлжээ) болон WAN(Интернэтийн сүлжээ) сүлжээнд ажиллах стандарт шаардлагуудыг хангасан байна.

2.1.1.2 Процессорын өргөжүүлэх боломж:

Процессор хэрэглэгчийн компьютерт 2 ширхэг буюу түүнээс дээш, сервэр компьютер 4 ширхэг буюу түүнээс дээш тооны процессортой байх шаардлагатай, Ингэснээр олон хэрэглэгчийн зэрэг хандалтыг эрсдэлгүй найдвартай зохицуулах боломжоор хангагдана.

2.1.1.3 Процессорын санах ой ба бусад хадгалах багтаамж:үндсэн санах ой 4GB; нөөц санах ой 512MB; дискийн хадгалах багтаамж 1TB; CD/DVD-ROM; USB 2.0 Port

2.1.1.4 Боловсруулах нэгжийн тасалдалгүй ажиллах чадвар:

How-Swappable Hard Disk төхөөрөмж дэмждэг байвал тохиромжтой

2.1.1.5 Боловсруулах нэгжийн удирдлагын онцлог: *[жишээлбэл, онцлог болон нэмэлт стандартууд, дотоод болон зайны удирдлага; гэх мэтчилэн заах.]*

2.1.1.6 Боловсруулах нэгжийн оролт ба гаралтын тоног төхөөрөмж

QWERTY стандартын компьютерын гар, стандарт мауз болон 1GHz хурд бүхий сүлжээний карттай байна.

2.1.1.8 Боловсруулах нэгжтэй холбоотой бусад тоног төхөөрөмж, тоноглолууд: UPS-тэжээл баригч

2.1.2 Сүлжээнд холбогдох гаралт ба оролтын тоног төхөөрөмж

Гаралт оролтын зэрэгцэн ажиллах тоног төхөөрөмж

2.1.2.0 Ерөнхий шаардлага: Хэрэв өөрөөр тусгайлан заагаагүй бол, бүх холбогдсон гаралт ба оролтын төхөөрөмж нь А4 стандарт хэмжээст цаасыг ашиглах боломжтой байна.

2.1.2.1 Принтер-хэвлэгч машин:

Өндөр хурдтай, сайн чанарын хэвлэгч машин; (А4) стандарт хэвлэгч машин

2.2 Сүлжээ ба холбооны тодорхойлолт

2.2.1 Дотоод сүлжээ(үүд):

2.2.1.1 тоног төхөөрөмжболон программ хангамж:

Дотоод сүлжээний хурд нь 100Mhzбуюу түүнээсилүү хурдтай байх ба өгөгдөл дамжуулах протокол нь TCP байна.

2.2.1.2 Холболт:

Сүлжээний холболтын утас нь UTP стандартын кабель байна.

2.2.2 Гадаад сүлжээ:

2.2.2.1 тоног төхөөрөмжболон программ хангамж:1MB хурд бүхий интернэт холболт шаардлагаттай

2.2.2.2 Харилцаа холбооны үйлчилгээ:

2.3 Программ хангамжийн тодорхойлолт

2.3.1 Системийн программ хангамж болон системийн удирдлагын байгууламжууд:

2.3.1.1 Өгөгдлийн сангийн сервэр: Өгөгдлийн сангийн сервэр нь Windows эсвэл Linux сервэр үйлдлийн системтэй байна.

2.3.2 Сүлжээний болон холбооны программ хангамж:

Өгөгдлийн сангийн мэдээлэл дамжуулах протокол TCP байх ба порт нь 3050-3080 интервалд тодорхойлогдсон байна.

2.3.3 Үндсэн программ хангамж:

ERP систем нь дараах дэд модулиудаас бүрдэнэ.

1. Хүний нөөцийн модуль

   Байгууллагын ажилтан албан хаагчийн дэлгэрэнгүй бүртгэл, хүний нөөцтэй холбоотой тушаал шийдвэр өргөдөл гомдлын бүртгэл бүхий модуль

2. Цаг бүртгэлийн модуль

   Байгууллагын ажилтан албан хаагчдын цаг бүртгэл хөтлөх, тайлан бэлтгэх зориулалттай, цаг бүртгэлийн төхөөрөмжтэй холбогдон ажиллах дэд модуль байна.

3. Цалингийн модуль

   Ажилтан албан хаагчдын сар бүрийн цалингийн тооцоолол хийх дэд систем байна.

4. Харилцагчийн удирдлагын модуль

   Харилцагчтай холбоотой гэрээ контракт болон түүхчилсэн бүртгэл хөтлөх боломжтой дэд систем.

5. Нягтлан бодох бүртгэлийн модуль

   Санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын үндсэн систем байна.

2.3.4 Мэдээллийн сангийн программ хангамжба боловсруулах арга хэрэгслүүд:

Өгөгдлийн сан нь PostgreSQL, Oracle өгөгдлийн сан удирдах системүүд байж болох ба анхан шатны туршилтын хувилбарт Firebird өгөгдлийн сан удирдах системийг ашигласан байна.

2.3.5 Хэрэглээний программ хангамж:

Хэрэглэгчийн компьютерт Microsoft Office Excel 2013 буюу түүнээс дээш хувилбарын оффис хэрэглээний программ суурилуулагдсан байх ба Kaseprsky Antivirus эсвэл түүнтэй дүйцэхүйц вирусээс хамгаалах программ хангамжтай байна.

2.4 Системийн удирдлага, зохион байгуулалт, аюулгүй байдлын тодорхойлолт

2.4.0 Ерөнхий шаардлага: Системийг бүрдүүлэгч олон төрлийн техник хангамж болон программ хангамжийн талаар бүлэг бүрт дурдсан удирдлага, зохион байгуулалт болон аюулгүй байдлын шаардлагаас гадна систем нь дор дурдсан удирдлага, зохион байгуулалт, хамгаалалтын онцлогуудыг системийн нэгдсэн түвшинд бүхэлд нь хангасан байна.

2.4.1 Техникийн удирдлага ба саадгүй ажиллагаа:

2.4.2 Хэрэглэгч ба ашиглалтын зохион байгуулалт:

2.4.3 Хамгаалалт, аюулгүй байдал:

2.5 Үйлчилгээний тодорхойлолт

2.5.1 Системийн нэгдмэл байдал:

ERP системийн модулиуд нь бие даан ажиллах боломжтой байхаас гадна өөр хоорондоо уялдан ажиллах, мэдээлэл хуваалцах, солилцох боломжтойгоор зохион байгуулагдсан байна. Бусад системүүдтэй уялдан ажиллах боломжтой байна.

Э-Баланс – Сангийн яамны ААН-ийн тайлан хүлээн авах систем

Э-Тайлан – Сангийн яамны төсөвт байгууллагын тайлан хүлээн авах систем

СТАУС – Төрийн аудитын нэгдсэн систем

Нийгмийн даатгал - НДШ-ийн тайлан, мэдээ

ҮТЕГазар – ХХОАТ-ын тайлан мэдээ

2.5.2 Сургалт ба сургалтын материал:

2.5.2.1 Хэрэглэгч: Хэрэглэгчийг гарын авлагаар хангана.

2.5.2.2 Техникийн асуудал: Интернэт орчинд ажиллана

2.5.3 Техник хангамж:

2.5.3.1 Баталгаат засвар:

Программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулах гэрээний баталгаат хугацаан дахь ажил үйлчилгээг утсаар, интернэтээр эсвэл захиалагчийн ажлын байранд биечлэн очиж үзүүлнэ.

2.5.3.2 Хэрэглэгчид туслах / галын шугам: Баталгаат хугацаанд үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх бөгөөд тухай бүр зөвлөгөө өгөх, интернэтээр үйлчилгээ үзүүлэх зэргээр тулгарсан асуудал бэрхшээлийг нэн даруй шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

2.5.3.3 Техник туслалцаа: Өгөгдлийн сантай ажиллах болон өгөгдлийн сангийн аюулгүй байдлыг хангах үүднээс нөөц хуулбар үүсгэх болон нөөц хуулбарыг сэргээх зэрэг механик ажлын зааварчилгааг гарган өгөх ба тухай бүр утсаар, интернэтээр шаардлагатай бол биечлэн очиж зөвлөгөө өгнө.

2.5.3.4 Баталгаат хугацаанаас хойших засвар үйлчилгээ: Баталгаат хугацаа дууссанаас хойш аливаа засвар үйлчилгээг гэрээний талууд харилцан тохиролцож хийж гүйцэтгэх бөгөөд шаардлагатай бол нэмэлт гэрээ байгуулж гүйцэтгэнэ.

2.5.4 Өгөгдлийг хөрвүүлэх болон шилжүүлэх:

ERP систем нь өгөгдлийн одоо ашиглагдаж байгаа бусад системээс (санхүүгийн болон тайлангийн нэгтгэлийн программ хангамжууд) өгөгдөл татаж оруулах ба эдгээр өгөгдлүүд нь харилцан адилгүй стандартаар хийгдсэн цаг хугацааны зөрүүтэй боловсруулагдсан зэргээс шалтгаалан тухай бүрчлэн механик аргаар хөрвүүлэх шаардлагатай болно.

2.6 Баримтжуулалтын шаардлага

2.6.1 Эцсийн хэрэглэгчийн баримт бичиг: Эцсийн хэрэглэгчид зориулсан гарын авлагаар үнэ төлбөргүй хангах бөгөөд эцсийн хэрэглэгчийн гарын авлагад дараах зүйлсийг агуулсан байна.

- Сангийн сайдын тушаалаар батлагдсан ангилал, кодчлол стандартууд
- Санхүүгийн тайлангийн стандарт маягтууд

2.6.2 Техникийн баримт бичиг: Тайлан илгээх, хүлээн авах ажиллагаатай холбогдсон техник ажиллагааны зааварчилгааг гарган өгнө.

БҮЛЭГ №4. ШАЛГАЛТ ТУРШИЛТ БА ЧАНАРЫН БАТАЛГААНЫ ШААРДЛАГА

3.1 Шалгалт

3.1.1 Үйлдвэр дээрх шалгалт:

ERP системийг хэсэгчилсэн болон нэгдсэн байдлаар шалгалт явуулах бөгөөд энэ нь программ хангамжийн компани буюу гүйцэтгэлийн ажлын байранд хийгдэх хяналт байна.

3.1.2 Санхүүгийн программ хүргэгдсэний дараах шалгалт:

Энэ шалгалт нь программын анхны хувилбарыг хэрэглэгчийн компьютер эсвэл сервэрт суурилуулсны дараа хэвийн ажиллагааг хангахад чиглэгдсэн хяналт байх ба тухай бүр CheckListгаргаж протокол хөтөлсөн байна.

3.2 Урьдчилсан туршилт

3.2.0 Нийлүүлэгчийн хийх стандарт шалгалт, туршилтаас гадна систем болон дэд системийг суурилуулахаас өмнө нийлүүлэгч (захиалагчийн туслалцаатайгаар) дараах туршилтыг гүйцэтгэх ёстой ба уг туршилтын дараа захиалагч программыг суурилуулсан тухай тэмдэглэл хөтөлж гүйцэтгэгчид хүлээлгэн өгнө.

3.3 Ашиглалтад хүлээн авах

3.3.0 Захиалагч нь (нийлүүлэгчийн тусламжтайгаар) суурилуулалтын дараа систем болон дэд систем нь ашиглалтад хүлээн авах шаардлагад бүрэн нийцсэн эсэхийг шалгах туршилтыг гүйцэтгэнэ. Туршилтыг гүйцэтгэхдээ доод шатны нэгжээс эхлэн гүйцэтгэх ба дараах байдлаар туршилтын ажлыг гүйцэтгэнэ.